



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 09 сарын 12 өдөр

Дугаар 5/97

Бодь

Т.Эрдэнэцэцэгийг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр хавсран гүйцэтгэх ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1.22, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр хавсран гүйцэтгэгч Т.Эрдэнэцэцэгийг 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2.Т.Эрдэнэцэцэгийн ажлыг хүлээлцэх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Т.Эрдэнэцэцэгийн ажилласан хугацааны цалин амралтын мөнгө, урамшуулал зэргийг олгож холбогдох санхүүгийн тооцоог дуусгахыг Нягтлан бодогч (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.


4.Т.Эрдэнэцэцэгийн ажлыг хүлээлцэхэд холбогдох хууль тогтоомж, заавар журмыг чанд мөрдөж, акт тэмдэглэл хөтөлж хариуцлагатай ажиллахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА  Р.БАТЖАРГАЛ

642201187

Сумын Засаг даргын 2022 оны 09 дугаар  
сарын 12 -ны өдрийн 5/97 тоот  
захирамжийн хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч

Н.Сумъяа

(Засаг даргын орлогч)

Гишүүдэд

Н.Хорлоо

(Хууль эрх зүй дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн)

Б.Батбаяр

(Нягтлан бодогч)

М.Оюунбилэг

(Архив, бичиг хэргийн эрхлэгч)

Л.Ганболд

(Нярав)

\_\_\_\_\_ оОо \_\_\_\_\_